



MONGOLIA
MINISTRY OF FOREIGN AFFAIRS
THE MINISTER

ТАЛАРХАЛ

**ЯПОН УЛСЫН "ALL LIFE LINE NET" ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
ТАКУО КИДОКОРО ТАНАА**

Монгол орны хөгжил дэвшилд Японы ард түмний олон талт тусламж, дэмжлэг, Япон Монголын олон жилийн түүхт харилцаа, хамтын ажиллагаа, түншлэлийн үйл явц онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн.

Үүнийг Япон Улсын Засгийн Газар болон Японы ард түмэн Монгол улсын боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам тээвэр зэрэг нийгмийн бүхий л салбаруудад нэн шаардлагатай, үр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийж ирсний үр дүн гэрчилнэ. Ялангуяа ноён Т.Кидокоро таны Монгол Улсад элчин сайдаар томилогдон ажиллах үедээ хэрэгжүүлсэн олон үйл ажиллагаанууд баталдаг. Нийгэм, эдийн засгийн шилжилтийн үеийн хүнд хэцүү цагт Японы ард түмний халуун сэтгэлийн тусламж дэмжлэгээр Монголын цахилгаан станцууд, нүүрсний уурхай, хүн эмнэлэг, гал команд, нийтийн тээвэр зэрэг байгууллагууд аюулгүй ажиллагаатай болж, олон арван цэцэрлэг сургуулиуд баригдсан нь манай улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр болж байна.

Түүнчлэн, Япон Улсын Засгийн Газраас Монгол Улсад үзүүлж буй оюуны үнэтэй хөрөнгө оруулалтын нэг баталгаа нь Монгол Улсын Боловсролын их сургууль дээр хэрэгжиж буй Моноцүкири төсөл юм. Энэ төслийн хүрээнд импортын өндөр өртөг бүхий бүтээгдэхүүнийг орлох бүтээгдэхүүнүүд бий болж, Монгол Улсын ерөнхий боловсрол, түүн дотроо байгалийн ухааны хичээлийн сургалт чанарыг сайжруулах, монголын ирээдүй хойчийг өндөр боловсролтой, бүтээлч сэтгэлгээтэй иргэд болгон хөгжүүлэх зорилго бүхий инновацийн бүтээгдэхүүнийг зохион бүтээж ерөнхий боловсролын сургуулиудад түгээж буй нь өндөр үр ашигтай байна.

Энэхүү ажлыг санаачлан, гүйцэтгэн хэрэгжүүлж буй Ноён Такүо Кидокоро болон танай хамт олонд чин сэтгэлийн талархал хүргэж байгааг минь хүлээн авна уу.

Хүндэтгэсэн,

ДАМДИНЫ ЦОГТБААТАР

Улаанбаатар хот, 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдөр

感謝状

日本国 認定特定非営利活動法人 All Life Line Net NPO 理事長 城所卓雄 殿

モンゴル国の発展に日本国民の多種の援助・協力、日本とモンゴルの長年に渡る友好関係に重要な役割を果たされたことの証明は日本政府・日本国民の援助でモンゴルで実施された多くのプロジェクト例えば；医療・農業・教育・インフレなど最重要分野への有効な投資となりました。特に、城所卓雄氏が在モンゴル特命全権大使でいらっしゃった際に実施した多くのプロジェクトの効果が表します。

経済市場移行の厳時に日本国民皆様の暖かい援助でモンゴルの発電所、消防署、病院、交通が安全に機能出来るようになり、多くの幼稚園や学校が建てられたことがモンゴルの発展に多大な貢献をされました。

更に、日本政府のモンゴルへの大きな投資の一つはモンゴル国立教育大学で実施している理科教材開発のプロジェクトであります。

高価の輸入教材の代わりに教材を国内で開発し、モンゴルの教育分野、中では理科教育の質の向上をはかり、更に、モンゴルの将来を担う子ども達に質の良い教育を与えることで”ものづくり”という考え方をを持った国民に育てていく事を目的とした新しいイノベーションの定着と同時に理科教材の学校への配付がモンゴルの教育分野に大きな効果をもたらしています。

このプロジェクトを実施している城所卓雄様および All Life Line Net NPO の皆様に心より感謝の意を表します。

モンゴル国 国会議員 外務大臣 ツォグトバートル.D

2019年2月4日 ウランバートル市